



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/272

Улаанбаатар хот


Авлигын эсрэг нийслэлийн 2016 оны
үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай” 23/01, “Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 32/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Авлигын эсрэг нийслэлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

111020001124



АВЛИГЫН ЭСРЭГ НИЙСЛЭЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Үйл ажиллагааны төсөв /сая төг/	Хариуцан зохион байгуулах газар, хэлтэс	Хүрэх үр дүн
Нэг. Хуулиар хүлээсэн үүрэг, удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх чиглэлээр						
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг цахим болон бусад хэлбэрээр сурталчлах Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх зардлыг батлах, нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг нэгтгэн тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх, төлөвлөгөөний үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	5.0	ННЗБ-ууд	Нийслэлийн удирдлагын бодлого, шийдвэр, мэдээ мэдээллийг иргэд тухай бүр хүлээн авч, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдээ мэдээллийг тухай бүр мэдээлэх боломж нэмэгдэнэ.
2			1 дүгээр улирал	-	ННЗБ-ууд	
3	Төрийн хяналт шалгалтын ил тод байдлыг нээлттэй хангах	Тухайн жилд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад явуулах хяналт шалгалтын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г баталж, цахим хуудаст байршуулах	1 дүгээр улирал	-	НЗДТГ, ХШХ	Төрийн хяналт, байгууллагын хариуцлагын тогтолцоо нэмэгдэнэ.

4	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж түүний хуваарилалтыг хуулийн хугацаанд цахим хуудас олон нийтэд тухай бүр мэдээлэх	Хийсэн хяналт шалгалтын дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулах Концессын зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх Концессын гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх	Тухай бүр	-	ННЗБ-ууд, ХШУХ	Нийслэлийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд олон нийтэд нээлттэй болсноор иргэдийн хяналт сайжирч, төсвийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй болж, хяналт тавих боломж бүрдэнэ.
5	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг нээлттэй болгох	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудаст ил тод мэдээлэх Тухайн зөвшөөрлийг олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, шийдвэрлэх журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрлийн эхлэх, дуусах хугацааг олон нийтэд мэдээлэх	Тухай бүр	-	НЭЗХГ	Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, бүртгэл хураамжийн мэдээлэл ил тод болно.
6	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй	Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, албан хаагчийн	Тухай бүр	-	ННЗБ-ууд	Байгууллагын хүний нөөцийн талаарх мэдээлэл олон нийтэд

	танилцах боломжоор хангах	ажиллах журам, харилцах угас зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээлэх				ил тод болно.
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Худалдан авах ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Тухай бүр	-	ННЗБ-ууд, НХААГ	Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, нээлттэй болж, иргэн, аж ахуй нэгж байгууллага худалдан авах ажиллагаанд эрх тэгш оролцох бололцоо бүрдэнэ.
9	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг журмын дагуу зохион байгуулах, урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй албан тушаалт томилсон тохиолдолд хариуцлага тооцож, нийтэд мэдээлж ажиллах	Жилдээ	-	ННЗБ-ууд	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж хэвших, мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар мэдлэгээ бататгана.
		Эрх бүхий албан тушаалтнууд, мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар сургалт зохион байгуулах, гарын авлага материал тараах	Жилдээ	-		

Хоёр. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт

<p>“Нээлттэй Улаанбаатар-2016” Авлигын эсрэг олон улсын 2 дугаар форумыг зохион байгуулах</p>	<p>4 дугаар улирал</p>	<p>30.0</p>	<p>НЗДТГ, Ил тод Улаанбаатар академи-Зөвлөлдөх ардчиллын танхим, ОУБ, Төрийн болон төрийн бус байгууллага</p>	<p>Монгол улсын авлигатай тэмцэх санал санаачилга, нэр хүнд Ази, бүс нутгийн хэмжээнд өсч, манлайлах боломж бүрдэнэ.</p>
<p>Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийг Баянзүрх, Хан-Уул, Сонгиохайрхан дүүргүүдэд байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулах, сурталчлах</p>	<p>1 дүгээр улирал</p>	<p>50.0</p>	<p>НЗДТГ, ННЗБ-ууд</p>	<p>Төрийн үйлчилгээг иргэд нэг цэгээс авах боломж бүрдэнэ.</p>
<p>Нийслэл дүүргийн сонгуулийн хороод, нам эвслийн сонгуулийн хороод, нэр дэвшигчдийн санхүүжилтийг иргэд, олон нийтэд мэдээлэх</p>	<p>3, 4 дүгээр улирал</p>	<p>-</p>	<p>ННЗБ-ууд</p>	<p>Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт ил тод болж, хяналтын тогтолцоо нэмэгдэнэ.</p>
<p>Төрийн захиргааны төв байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг хандалт өндөртэй үйлчилгээнүүдийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлэх замаар засаглалын /үйлчилгээний/ ил тод, нээлттэй, шуурхай байдлыг сайжруулах /бэхжүүлэх/</p>	<p>1, 2 дугаар улиралд</p>	<p>-</p>	<p>НЗДТГ, ННЗБ-ууд,</p>	<p>Төрийн үйлчилгээнд шинэ соёл нэвтэрч, үйлчилгээ нэг цэгт төвлөрсөн байна.</p>
<p>Алигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ</p>	<p>1, 2 дугаар улиралд</p>	<p>-</p>	<p>НЗДТГ, ННЗБ-ууд</p>	<p></p>

Худалдан авах ажиллагааны хяналт, мэдээллийн системийг бий болгох замаар мэдээллийг нэгтгэж, төсөл арга хэмжээний мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх	1,2 дугаар улиралд	-	НЗДТГ, НХААГ	Тендер шалгаруулалтад оролцож байгаа оролцогчдод мэдээллийг цаг хугацаанд нь өгөх, тендер шалгаруулалтад оролцогчдыг тэгш боломжоор хангах боломж бүрдэнэ.
Худалдан авах ажиллагааг иргэдэд нээлттэй болгох, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа дахь хяналтыг сайжруулах “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны танхим”-ыг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд шинээр байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	1,2 дугаар улиралд	10.0	НЗДТГ, НХААГ	
Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний цэсийг бий болгох	1-2 дугаар улиралд	-	НЗДТГ, Хэрэгжүүлэгч агентлагууд	Үйлчилгээ авахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, үйлчилгээний нэр төрөл, ил тод, нээлттэй болж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс албан хаагчдыг урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.
Нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний хөлсийг тогтоох замаар “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн бие даасан байдлыг хангаж, үйлчилгээг иргэдийн эрх ашиг, сонирхолд нийцүүлэх	1-3 улиралд	-	НЗДТГ	
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мөрдөн ажиллах захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журмыг шинэчлэх	1,2 дугаар улиралд	-	НЗДТГ	Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх, үйл ажиллагаа боловрсонгуй болно.

		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрэх горимыг цахим түлхүүр /карт/-ийн хэлбэрт шилжүүлэх	2 дугаар улиралд	20,0	НЗДТГ, НМТГ	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломж сайжирч, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлээс хамгаалагдана.
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээний журмыг шинэчлэн, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах	2 дугаар улиралд	-	НЗДТГ, Хэрэгжүүлэгч агентлагууд	Үйлчилгээний хөгжлийн чиг хандлага, техник технологийн дэвшил, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байна.
		Улаанбаатар хотын гэр хороололд төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн оролцоотой төсвийн төлөвлөлтийг дэмжих Хотын Засаглал төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	Жилдээ	Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилт	НЗДТГ, Швейцарийн хөгжлийн агентлаг	Нийслэлийн гэр хороололд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн бодит оролцоо нэмэгдэнэ.
		Мэдээллийн ил тод байдал, нээлттэй засаглалыг бэхжүүлэх ажлын хүрээнд "Ил тод-Нээлттэй Улаанбаатар" 1000 сэтгүүлчийн форумыг зохион байгуулах	1 дүгээр улиралд	5.0	НЗДТГ,МСНЭ	Нээлттэй засаглал, төрийн мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ.
		Мэдээллийн ил тод нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ардчиллын суурь үнэлгээг хийх	3,4 дүгээр улирал	10.0		
11	Авлигын талаар нийслэлийн иргэдэд мэдээлэл өгч, соён гэгээрүүлж, тэдний оролцоог хангах "Ил тод Улаанбаатар академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулна.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, нийслэлийн хөгжлийн бодлогын чиглэлээр зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах	2 дугаар улирал	8,0	НЗДТГ, Ил тод Улаанбаатар Академи	Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.

		Ази бүс нутагт ардчиллын ил тод байдлыг дэмжих шинжээчдийн анхдугаар уулзалтыг зохион байгуулах	2 дугаар улирал	10.0			Худалдан авах үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэж, шударга байдал нэмэгдэнэ.
	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах үйл ажиллагааны явц байдалд хяналт тавих, судалгаа дүн шинжилгээ хийх ажлыг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Жилдээ	15.0	НЗДТГ, ТББ-ууд		Авлигыг бууруулах чиглэлээр иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан санал санаачилгыг хэрэгжүүлж ажилласан байна.
		Авлигатай тэмцэх асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын судлаач, эрдэмтдийг урьж сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Жилдээ	10.0	НЗДТГ, Ил тод Улаанбаатар Академи		Шийдвэр гаргах хэлэлцэх, батлах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.
		Авлигатай тэмцэхэд иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, "Авлигын эсрэг Олон нийтийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилдээ	5.0	НЗДТГ, Авлигын эсрэг олон нийтийн зөвлөл		Ажлын жагсаалтыг гаргаж иргэдээр хэлэлцүүлэн, хувийн хэвшлийг үйл ажиллагаанд татан оролцуулсан байна.
		Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээний жагсаалт гаргах, иргэдээр хэлэлцүүлж олон нийтэд мэдээлэх	Жилдээ	-	НЗДТГ, ННЗБ-ууд		Албан хаагчдын ёс зүй дээшилж, ашиг
		Төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн	2 дугаар улирал	5.0	ННЗБ-ууд, НЗУХ		

13	Албан хаагчдын шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх	талаар сургалт зохион байгуулах, шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох	Жилдээ	-	ННЗБ-ууд	сонирхлын зөрчил үүсэх нөхцөл буурна.
Албан хаагчдын шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх	Байгууллагын өргөдөл, гомдлын программыг боловсронгуй болгох, мэдээлэл шинэчлэгдэх боломжийг нэмэгдүүлэх	Жилдээ	5.0	НЗУХ, НУНТ, НМТГ	Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлийн хугацаа богиносгож, мэдээллийн баяжилт нэмэгдэж, техникийн үзүүлэлт сайжирсан байна.	
Төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халах, тушаал бууруулах, хууль ёсны эрх ашгийг нь хохироох, нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор санаатайгаар гүтгэсэн нь тогтоогдвол нэр төрийг нь сэргээх, хамт олон, олон нийтэд мэдээлдэг болох	Төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халах, тушаал бууруулах, хууль ёсны эрх ашгийг нь хохироох, нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор санаатайгаар гүтгэсэн нь тогтоогдвол нэр төрийг нь сэргээх, хамт олон, олон нийтэд мэдээлдэг болох	Жилдээ	-	ННЗБ-ууд	Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүл хамгаалагдана.	
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод аудитын хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод аудитын хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах	Жилдээ	-	НДАА, Дүүргүүдийн Дотоод Аудитын алба	Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар нэмэгдэж ёс зүй, шударга байдлын түвшин, хариуцлагын тогтолцоо дээшилсэн байна.	

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр

	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх талаар үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах</p>	Жилдээ	-	НЗДТГ, ННЗБ-ууд	<p>Нийслэлийн удирдлагын бодлого, шийдвэр, мэдээ мэдээллийг иргэд тухай бүр хүлээн авч, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдээ мэдээллийг тухай бүр мэдээлэх боломж нэмэгдэнэ.</p>
14	<p>Авлигын эсрэг явуулж бодлого, иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээ иргэн, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх</p>	2 дугаар улиралд	3.0	НЗДТГ, ХМОНХХ	
	<p>Байгууллагын мэдээллийн самбарыг шинэчлэн, сайжруулах, мэдээллийн баяжилт хийх боломжийг нэмэгдүүлэх</p>	1 дүгээр улирал	2.0	НЗДТГ, НЗУХ	
	<p>www.ulaanbaatar.mn хуудасны мэдээллийг төрөлжүүлэх, хэрэгцээт мэдээллийг богино хугацаанд олж авах боломжийг нэмэгдүүлэх, “Авлигын эсрэг үйл ажиллагаа” буланг хөгжүүлэх мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах</p>	Жилдээ	-	НЗДТГ, НЗУХ	<p>Нийслэлийн удирдлагаас гарч байгаа шийдвэрүүд, төрийн үйлчилгээ, иргэдэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг тухай бүр мэдээлдэг тогтолцоо бий болж, иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэр, төрөл, үйлчилгээний төлбөрийн талаарх</p>

	мэдээлэл ойлгомжтой болсон байна.	иргэдэд хүрдэг			
15	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, ёс зүйн мэдэгдэл гаргаж хэвшүүлэх, хэрэгжилтийг мэдээлэх</p> <p>Ёс зүйн дүрмийн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх</p> <p>Зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах сургалтыг зохион байгуулах</p>	<p>Жилдээ</p> <p>Жилдээ</p> <p>2 дугаар улирал</p>	2.0	НЗДТГ, НЗУХ	Албан хаагчдын ёс зүй дээшилж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл буурна.
16	<p>АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах</p>	Жилдээ	-	НЗДТГ, ННЗБ-ууд	Авлигаас урьчилан сэргийлэх удирдлагын хүчин чармайлт нэмэгдэж, авлига гарах эрсдэл буурна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР